

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Архангай аймаг дахь
Төрийн аудитын газар
2021



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ | 2021
ТАЙЛАН



1

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

- | | | |
|---------------------|---|---|
| Нэгдүгээр бүлэг: | ● | Удирдлага зохион байгуулалт |
| Хоёрдугаар бүлэг: | ● | Санхүүгийн тайлангийн аудит |
| Гуравдугаар бүлэг: | ● | Гүйцэтгэлийн аудит |
| Дөрөвдүгээр бүлэг | ● | ИТХ-ын захиалгат болон өөрийн санаачилгаар хийсэн аудит |
| Тавдугаар бүлэг: | ● | Дотоод ажил |
| Зургаадугаар бүлэг: | ● | Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл |
| Долоодугаар бүлэг: | ● | Дүгнэлт, санал |
| Наймдугаар бүлэг: | ● | Статистик мэдээ |



ЗОРИЛТ

Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны А/09 тушаалаар Төрийн аудитын байгууллагын 2021 оны зорилтыг “**Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог бүрдүүлэн, төлөвшүүлэх**” гэж тодорхойлон баталсан.

Энэ зорилтын хүрээнд батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд үндэслэн аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5-н бүлэг, 9-н дэд зорилтын хүрээнд 41-н арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн төлөвлөгөөг Монгол Улсын ерөнхий аудиторын орлогч болон Тамгын даргаар батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллалаа.

Төрийн аудитын байгууллагын 2021 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараах цахим системийг аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж байна.

www.local.audit.mn-д АУДИТЫН ЦАХИМ БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ дараах мэдээллүүдийг бүртгэлээ.

- ✓ Шилэн дансны мэдээлэл 265 байгууллага, нэгжийн мэдээллийг холбогдох маягтын дагуу бүртгэлээ.
- ✓ Аудитын шалгагдагч этгээдийн бүртгэлд 249 байгууллагын мэдээллийг орууллаа.
- ✓ Статистик мэдээллийн нэгдсэн системд 8 маягтаар 2020 оны 268 байгууллагын 416, 2021 оны 264 байгууллагын 687 мэдээллийг оруулж цахимжууллаа.


www.hr.audit.mn Хүний нөөцийн цахим системд байгууллагын 12 албан хаагчийн холбогдох мэдээллийг бүрэн орууллаа.

www.Data.audit.mn системийг ашиглан аудитын явцын мэдээллийг 14 хоног тутам АНГ-т мэдээлж хэвшлээ.

www.surgalt.audit.mn Төрийн аудитын байгууллагын сургалт хөгжлийн системд байршуулсан ТАБ-ын ажилтнуудын нэгдсэн цахим сургалтад алба хаагчид бүрэн хамрагдлаа.

www.able.audit.mn Албан хэрэг хөтлөлтийн системийг бүрэн ашиглаж алба хаагчдын цагийн бүртгэл, албан хэрэг хөтлөлтийг хийж хэвшлээ. Энэ системээр ҮАГ-ын бүтцийн нэгжийн байгууллага, албан хаагчидтай болон байгууллагын дотоодод мэдээллийг шуурхай боловсруулан ашиглаж байна.

www.fas.audit.mn Санхүүгийн тайлангийн аудитын нэгдсэн системд аудит хийх 247 байгууллагын хуваарийг байршуулаад байна.





❖ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 онд Монгол улсын Ерөнхий аудиторын А/02 тушаалаар батлагдсан 12 орон тоонд багтан, Төрийн аудитын газрын Тэргүүлэх аудиторын 2021 оны А/28 тушаалаар аудитын **нэг, хоёр, гуравдугаар нэгжийн** зохион байгуулалтад орж ажиллалаа.



Нийт албан хаагчдын 91 хувь нь эдийн засагч, нягтлан бодогчийн мэргэжилтэйгээс 50 хувь нь Мэргэшсэн нягтлан бодогчид байна. Ажилласан жилээр авч үзвэл нийт албан хаагчдын 42 хувь нь 6-10 жил, 33 хувь 11-15 жил тогтвортой, суурьшилтай ажиллаж байна. Насны бүлгээр авч үзвэл 67 хувь нь 31-40 нас, 33 хувь нь 41-50 хүртэл насны албан хаагчид байна.



❖ 2021 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТЫН ҮР ДҮН

ХУРААНГУЙ ТОЙМ

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 онд 163 аудитыг гүйцэтгэж, үүнээс санхүүгийн тайлангийн аудитад бие даасан 153 дүгнэлт гаргасан байна. Гүйцэтгэлийн 8 аудитыг хийж аудитад 28 байгууллага нэгжийн үйл ажиллагаа, нийцлийн 2 аудитад 26 хуулийн этгээд тэдгээртэй холбогдох талуудын үйл ажиллагааг хамруулан давхардсан тоогоор 62 хүн, 512 өдөр, 7742 цаг зарцуулан ажиллалаа.



Гүйцэтгэсэн аудитын дүнгээр нийт 59,832.6 сая төгрөгийн 687 алдаа, зөрчил илрүүлж, тэдгээрийн 16.3 хувь 9,571.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулан, 50,261.6 сая төгрөгийн 625 зөрчилд аудитын шийдвэрийг хүргүүлсэн байна.

АУДИТААР ИЛЭРСЭН НИЙТ АЛДАА ЗӨРЧИЛ	59,832.6 сая
АУДИТЫН ЯВЦАД ЗАЛРУУЛСАН АЛДАА	9,571.0
АУДИТААР ЗАЛРУУЛАХ БОЛОМЖГҮЙ ЗӨРЧИЛ	50,261.6



Тайлангийн жилд нэгдсэн удирдамжаар 5 гүйцэтгэлийн аудит, ИТХ-ын санаачлагчаар 2, өөрийн санаачлагчаар -2, өргөдөл гомдлын дагуу 1 гүйцэтгэл нийцлийн аудитыг хийж аудитын тайланг ҮАГ болон аймгийн ИТХ, Засаг дарга, шалгагдагч байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

Төрийн аудитын газар нь 2021 онд орон нутгийн төсөвт 99.7 сая төгрөгийг төвлөрүүлэн, нийт **54,081.7** сая төгрөгийг аудитад хамрагдсан байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан нэг төгрөгийн санхүүжилт тутамд **105.2** төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Төрийн аудитын тухай хуулийн 6.3.2 дахь заалтын хүрээнд аймаг нийслэлийн засаг даргаас тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх гэж заасны дагуу 2022 оны төсвийн төсөлд орлогыг **781.2** сая төгрөгөөр нэмэгдүүлэх, төсвийн үр ашиг дээшлүүлэх 7-н санал хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.



Аудитын дүнд нийт илрүүлэлтийн 33.5% нь хууль тогтоомжийн хэрэгжилт, 30.1% нь нягтлан бодох бүртгэл тайлагналтай, 24.2% нь дотоод хяналт хариуцлагатай холбоотой, 12.2% нь худалдан авалт арвилан хэмнэлттэй холбоотой зөрчил байна.

Төлбөрийн акт: Тайлант онд **143.9** сая төгрөгийн 52 төлбөрийн акт тогтоосон нь өмнөх онтой харьцуулахад 16 хувиар өссөн үзүүлэлт юм. Тогтоосон актаас 97.7 сая төгрөгийн 50 төлбөрийн актын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, тайлангийн хугацааны 46.2 сая төгрөгийн 2 акт дараа онд шилжиж байна.

Албан шаардлага: Тайлант онд **19,008.1** сая төгрөгийн 169 албан шаардлагыг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлт юм. Тус албан шаардлагаас **17,899.2** сая төгрөгийн 167 албан шаардлагын биелэлтийг хангуулж, 1108.9 сая төгрөгийн 2 албан шаардлагын хэрэгжих хугацаа он дамнахаар байна. Тайлангийн хугацаанд **31,109.6** сая төгрөгийн **397** зөвлөмжийг өгсөн нь өмнөх оноос 6 дахин өссөн үзүүлэлттэй байна. Тайлангийн жилд тайлант хугацааны болон өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 8, гүйцэтгэлийн аудитаар 1 нийт зөрчил гаргасан 9 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэн биелэлтийг бүрэн хангууллаа.

Хууль хяналтын байгууллагад тайлант онд 12.0 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг шилжүүлж, өмнөх оны 153.4 сая төгрөгийн 5 асуудал нийт 165.4 сая төгрөгийн 7 асуудал хянагдаж байна.





2 | САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН
АУДИТ




Бие даан дүгнэлт
гаргасан - 153
Түүвэрт хамрагдсан - 80
Итгэл үзүүлсэн - 18



9 аудитор
3 гэрээт ажилтан
2 ХАК
76 өдөр
3388 цаг илүү
ажилласан



9,571.0 сая
төгрөгийн алдааг
залруулсан



11,606.6 сая
төгрөгөнд 151 албан
шаардлага хүргүүлж,
биелэлтийг 100
хувь хангууллаа.



Хариуцлага тооцуулах
8 санал хүргүүлж,
биелэлтийг 100 хувь
хангууллаа.



Зөрчилгүй - 137
Хязгаарлалттай - 14
Санал дүгнэлт өгөхөөс
татгалсан - 2



Нийт 34,133.3 сая
төгрөгийн алдаа зөрчил
илэрсэн



98.2 сая төгрөгөнд 50
төлбөрийн акт
хүргүүлж, 96.6 сая
төгрөгийн төлбөрийн
актны хэрэгжилтийг
хангуулж, 1.6 сая
төгрөгийн төлбөрийг
акт дараа онд
биелэхээр байна.



12,857.4 сая төгрөгөнд
316 зөвлөмж хүргүүлж,
биелэлт 100 хувь
хангууллаа.



24,632.7 сая төгрөгийн
275 санхүүгийн, 242
санхүүгийн бус үр
өгөөжийг холбогдох
байгууллагуудаар
хүлээн зөвшөөрүүлээ.



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Архангай аймаг дахь Төрийн аудитын газар нь 2021 гүйцэтгэлийн төлөвлөгөө, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/64, Тэргүүлэх аудиторын 2020 оны А/17 дугаар тушаалаар баталсан хуваарийн дагуу 251 төсөв захирагч, байгууллага, аж ахуйн нэгжийн 2020 оны санхүүгийн тайланд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд тусгасан цаглаварт хугацаанд аудитыг гүйцэтгэсэн.

Аудитад ТАГ-ын үндсэн 9 аудитор, 3 гэрээт ажилтан, 2 ХАК оролцон, аудитын менежер болон Тэргүүлэх аудитор аудитыг хянан удирдаж, үе шатны хяналтыг хэрэгжүүлэн 76 өдөр, 3388 илүү цаг зарцуулан ажиллалаа. Нэг аудитор дунджаар 15 төсөв захирагчийн санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж ажилласан байна.

Аудитаас 153 бие даасан санал дүгнэлт гаргаж, 18 төсөв захирагчийн тайланд итгэл үзүүлэн, 80 тайланг түүвэрт хамрууллаа. Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т заасны дагуу 30 байгууллагын санхүүгийн тайланг аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн.

Аудитын санал дүгнэлтийн 89.5 хувь буюу 137 тайланд “Зөрчилгүй”, 9.2 хувь буюу 14 тайланд “Хязгаарлалттай”, 1.3 хувь буюу 2 тайланд Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Аудитаар нийт **34,133.3** сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлснээс **9,571.0** сая төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, **12,857.4** сая төгрөгийн зөрчилд **316** зөвлөмж, **11,606.6** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах **151** албан шаардлага, **98.2** сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх 50 төлбөрийн акт тогтоолоо. Аудитаар илэрсэн алдаа зөрчил өмнөх оноос 54 хувиар өссөн бөгөөд залруулагдаагүй **24,562.3** сая төгрөгийн аудитын шийдвэрийн 99.9%ийн хэрэгжилтийг хангууллаа.



Аудитаар **24,632.7** сая төгрөгийн 275 санхүүгийн, 242 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.



АЙМГИЙН ТЕЗ-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

 **Нэгтгэгдсэн 220
санхүүгийн тайлан**

 **Нийт хөрөнгө
221,077.4 сая төгрөг**

 **Нийт санхүүгийн үр
дүн 3,233.2 сая төгрөг**

 **30.9 сая төгрөгийн 3
албан шаардлага**

Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэсэн. ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд сумдын ТТЗ-ийн 19, төсвийн шууд захирагчдын 156, төсөл сангийн 41, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 4 нийт 220 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд аймгийн Засаг дарга дансны зардлын гүйлгээг хамрагдсанд нэгдсэн судалгаа хийн тулгалт хийж баталгаажууллаа.

Аудитад 2 аудитор, хянан удирдах ажилтнууд оролцож, 15 өдөр зарцуулан 185 илүү цаг зарцуулж аудитыг хугацаанд нь гүйцэтгэв. Мөн УАГ-т аймгийн ТЕЗ-ийн зөрчлийн нэгтгэл болон холбогдох 12 төрлийн судалгааг цаг хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна. Аудитын төгсгөлийн уулзалтыг аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, аймгийн ЗДТГ-ын дарга, СТСХ-ийн дарга нартай хийж, санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, аудитаар илэрсэн алдаа зөрчил, цаашид анхаарах асуудлуудын талаар танилцууллаа.

Аудитаас аймгийн Засаг дарга, СТСХ-ийн болон ОНӨГ-ын дарга нарт 2 заалт бүхий зөвлөмж, 30.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

 **Нийт орлого ба тусламж
78,428.7 сая төгрөг**

 **Нийт цэвэр зарлага ба
зээл 78,350.2 сая төгрөг**

 **6 зөвлөмж**

 **115.1 сая төгрөгийн 1
албан шаардлага**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасан цаглаварт хугацаанд аймгийн ТЕЗ-ийн 2020 оны жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, аудитын тайланг аймгийн ИТХ, засаг дарга болон УАГ-т хүргүүллээ.

Аймгийн ТЕЗ-ийн тайлагнасан төсвийн гүйцэтгэлийн нийт орлого ба тусламжийн орлого 78,428.7 сая төгрөг, нийт цэвэр зарлага ба зээлийн дүн 78,350.2 сая төгрөгийн гүйцэтгэл, 84,942.0 сая төгрөгийн төсвийн төлөвлөгөөг баталгаажууллаа.

Аудитад 2 аудитор, хянан удирдах ажилтнууд оролцож, 15 өдөр 151 илүү цаг зарцуулж ажилласан. Аудитаар төсвийн орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлээгүй, Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан зөрчилд **115.1** сая төгрөгийн зөрчлийг арилгах нэг албан шаардлага, аймгийн Засаг дарга, СТСХ-т 4 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлж хэрэгжилтийг хангууллаа.





СУМЫН ТТЗ-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасан цаглаварт хугацаанд 19 сумын Засаг даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, 18 сумын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Хашаат сумын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг хүргүүлсэн.

Аудитад ТАГ-ын 5 аудитор, хянан удирдах ажилтнууд, 1 гэрээт ажилтан оролцож нийт 19 өдөр зарцуулан, 397 цаг илүү ажилласан байна.

Аудитаар **4,133.8** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс **161.0** сая төгрөгийн алдааг залруулж, **648.1** сая төгрөгийн зөрчилд **19** албан шаардлага, **3,324.7** сая төгрөгийн зөрчилд **35** заалт бүхий зөвлөмжийг өгч хэрэгжилтийг хангууллаа. Албан үүргээ биелүүлээгүй, зөрчил дутагдал гаргасан 4 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн, биелэлтийг хангуулж ажиллалаа.

Аудитын дүнд үндэслэн сумын төсвийн орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлж, бодит тоо мэдээнд тулгуурлан орлогын төлөвлөлтийг хийх, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч, эргэн төлөлтийг эрчимжүүлэн ажиллах албан шаардлага, зөвлөмжийг бүх сумын Засаг дарга нарт хүргүүлсэн. Мөн сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах үүднээс зээлийн үлдэгдлийн судалгааг гарган Аймгийн Прокурорын газарт шилжүүлсэн.

ТБОНӨААН-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн дагуу 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглаварт хугацаанд ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлангийн аудитад орон нутгийн өмчит 4, төрийн өмчит 2 ААН-ийг хамрууллаа. Төрийн өмчит 2, орон нутгийн өмчит 3 нийт 5 ААН-ийн санхүүгийн тайланг гэрээний үндсэн дээр аудитын хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, санал дүгнэлтийг хүргүүлэн ажилласан бөгөөд аудитад хуулийн этгээдийн 4, ТАГ-ын 1 аудитор оролцон 20 өдөр зарцуулан 252 илүү цаг ажилласан байна.

Аудитаас Зөрчилгүй 1, Хязгаарлалттай 4, татгалзсан 1 санал дүгнэлтийг хүргүүлж, харин Авто тээврийн үндэсний төвийн Архангай аймаг дахь салбарын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

Аудитаар **8,120.9** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс **7,876.7** сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан, **85.8** сая төгрөгийн зөрчилд 12 албан шаардлага, **158.4** сая төгрөгийн зөрчилд 10 зөвлөмж хүргүүлэн, биелэлтийг хангууллаа. Аудитаас орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь өөрийгөө санхүүжүүлэх, үр ашигтай ажиллах үндсэн зарчмаа хангаагүй нийтлэг зөрчил илэрсэнд аймгийн Засаг даргад үр ашигтай ажиллуулах, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН САНХҮҮГИЙН АУДИТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглаварт хугацаанд улсын төсвийн 28, орон нутгийн төсвийн 197 нийт 225 төсвийн шууд захирагчдын тайланг аудитад хамруулан, 18 тайланд итгэл үзүүлэн, 79 тайланг түүвэрт хамруулан, 128 тайланд бие даасан санал дүгнэлт гаргалаа. Бие даасан санал






дүгнэлт гаргасан тайлангаас 117 тайланд “Зөрчилгүй”, 10 тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 1 тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтийг өглөө.

Аудитад ТАГ-ын үндсэн 9 аудитор, 3 гэрээт ажилтан, 2 аудитын хуулийн этгээд оролцон, аудитын менежер болон Тэргүүлэх аудитор хянан удирдаж, үе шатны хяналтын хэрэгжүүлэн 40 өдөр зарцуулж, 2404 илүү цаг зарцуулан ажилласан байна.

Аудитаар нийт **21,732.6** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад **1,533.4** сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулан, **98.2** сая төгрөгт **50** төлбөрийн акт тогтоож, **10,726.8** сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгах, таслан зогсоох **116** албан шаардлага, **9,374.2** сая төгрөгийн зөрчилд 265 зөвлөмжийг хүргүүллээ. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, 1.6 сая төгрөгийн төлбөрийн акт үлдэгдэлтэй байна. Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан, хууль тогтоомж зөрчсөн нийт 4 албан тушаалтанд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг хүргүүлэн биелэлтийг хангуулаад байна.



Аудитын үр дүн:

Аудитаар төсөвт байгууллагууд үндсэн хөрөнгийг холбогдох шийдвэргүй данснаас хасаж шилжүүлсэн, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг тайлан баланст бүртгэсээр байгаа зэрэг нийтлэг зөрчлүүдийг арилгах албан шаардлагыг хүргүүлж хэрэгжилтийг хангуулснаар үндсэн хөрөнгийн бүртгэл тооцоог үнэн зөв хийж, бүртгэл тайланд тусгасан, хадгалалт хамгаалалтыг сайжруулж хөрөнгө эзэнгүйдэх, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг үр дүнгүй, үр ашиггүй зарцуулагдах эрсдэлээс сэргийлсэн үр дүн, үр өгөөжийг бий болголоо.

ЗАВСРЫН АУДИТ

Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 101 төсөв захирагчийн 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийж гүйцэтгэлээ. Аудитад МУЕА-ын 2020 оны А/106, 2021 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлангийн заавар, аргачлал”-ыг баримтлан аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг санхүүгийн тайлангийн аудитын fas.audit.mn системээр гүйцэтгэж байна.





3

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

ГҮЙЦЭТГЭЛИЙН
АУДИТ



Нэгдсэн төлөвлөгөөт 5
Өөрийн санаачлага 1
ИТХ-ын захиалгат 1
Өргөдөл, гомдол 1



28 байгууллага хамрагдаж
тэдгээртэй холбогдох
талуудын үйл ажиллагааг
шалгав.



23 хүн /давхардсан
тоогоор/ 249 өдөр
зарцуулж 172 цаг
илүү ажилласан




Нийт 21,779.5 сая төгрөгийн
алдаа зөрчил илэрсэн



45.7 сая төгрөгөнд
2 төлбөрийн акт
хүргүүлж, биелэлтийг
100 хувь хангууллаа.



161.9 сая төгрөгийн 6
асуудал хууль хяналтын
байгууллагад хянагдаж
байна.



14,659.3 сая төгрөгөнд
47 зөвлөмж хүргүүлж,
14,659.3 сая төгрөгийн
25 зөвлөмжийн
хэрэгжилтийг
хангуулж, 22 зөвлөмж
дараа онд биелэхээр



7,074.5 сая төгрөгөнд 17
албан шаардлага
хүргүүлж, 5,965.6 сая
төгрөгийн 15 албан
шаардлагын
хэрэгжилтийг хангуулж,
1,108.9 сая төгрөгийн 2
албан шаардлага дараа
онд биелэхээр байна.



20,626.0 сая төгрөгийн 11 санхүүгийн, 48 санхүүгийн бус үр
өгөөж хүлээн зөвшөөрүүлж бүртгэсэн нь өмнөх оноос 19,545.3
сая төгрөгөөр илүү байна.



УЛСЫН ТӨСВИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ



152 тэрбум 409.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 77 төсөл арга хэмжээ

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 05-ны хооронд 3 аудитор 135 хүн өдөр зарцуулан гүйцэтгэж, Тэргүүлэх аудиторын 2021 оны 5 дугаар сарын 06-ны А/12 тоот тушаалаар баталгаажуулан ҮАГ, аймгийн ИТХ, Засаг дарга, тус тус хүргүүлсэн байна.



5,027.5 сая төгрөгийн 4 албан шаардлага 14,494.3 сая төгрөгийн 9 зөвлөмж

Аудитаар Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан **152,409.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих **47,013.0** сая төгрөгийн дүн бүхий 77 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг баримтаар шалгаж ажиллалаа.

Аудитаар **Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалттай, хүрэх үр дүнгийн 79.3%-ийг хангасан байна** гэсэн ерөнхий дүгнэлт хийж, илэрсэн алдаа зөрчилд 4 албан шаардлага, 9 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа. Мөн орон нутагт эрх шилжүүлсэн ТАХ-ний санхүүжилтэд хяналт тавих эрхийг хамт шилжүүлэх саналыг ТЕЗ нарт хүргүүлэхээр ҮАГ-т уламжилж ажиллалаа.

Аудитын үр дүн: Тайлант хугацаанд аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 100% хангуулан, нийт **19,521.8** сая төгрөгийн үр өгөөжийг бүртгэж харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлснээр хөрөнгийн болон санхүүжилтийн зарцуулалтад тавих хяналт сайжирсан, алдаа зөрчил давтан гарахаас сэргийлсэн үр дүнг бий болгож ажиллалаа.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Ерөнхийлөгчийн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийх аудитыг Аудитын Дөрөвдүгээр газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Тэргүүлэх аудиторын баталсан аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн хүрээнд 2021



Сонгуулийг аймгийн 1, сумын 19 сонгуулийн хороо, 105 хэсгийн хороотойгоор зохион байгуулсан.

оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 09-ны өдрийн хооронд 7 аудитор оролцож 7 өдөр зарцууллаа. Улсын төсвөөс аймгийн Сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбогдуулан нийт 680.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосны 90.8 хувийг сумын сонгуулийн хороо, 9.2 хувийг аймгийн сонгуулийн хорооны үйл ажиллагаанд зарцуулахаар тус тус хуваарилсан байна. Аудитын тайлан, дүгнэлтийг аймгийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд буюу 2021 оны 7 дугаар сарын 09-ний өдөр 241 тоот албан бичгээр Сонгуулийн хороонд хүргүүллээ.



ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОГТОЛЦОО, ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



Дотоодын үйлдвэрлэлээр 2020 онд 34.4 мянган тн мах, 56.0 мянган тн сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн



2 албан шаардлага 9 зөвлөмж дараа онд хэрэгжихээр байна.

Аудитыг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 03-ны хооронд 3 аудитор 45 өдөр зарцуулан тэргүүлэх аудиторын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны А/35 тоот тушаалаар баталгаажуулан ҮАГ, аймгийн ИТХ, Засаг дарга, МЭГ, ЭМГ, МХГ-дад тус тус хүргүүлсэн байна. Мөн аудитын нээлт

болон явцын зарим уулзалтыг цахимаар хийж харилцагч талуудтай хамтран ажиллалаа.

Аудитаас **Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо оновчтой бус төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн хангалтгүй байна** гэсэн ерөнхий дүгнэлтийг хийж, илэрсэн алдаа зөрчилд 2 албан шаардлага, 9 зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүллээ

Аудитын үр дүн: Аудитаас хүргүүлсэн шийдвэрээс төр хувийн хэвшлийн хоорондын ажлын уялдаа, хяналт шалгалт сайжрах үр дүнг бий болохоор байна. Шийдвэрийн хэрэгжилт 2022 оны нэгдүгээр улиралд биелэгдэх тул хяналт тавин ажиллаж байна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



СХАА нь сүүлийн 4 жилд 293 удаагийн санхүүгийн хяналтаар 3,018.4 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн



6 зөвлөмж хүргүүлж дараа онд хэрэгжихээр байна

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөөний хүрээнд “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д хийх гүйцэтгэлийн аудитын аудитын дэд төлөвлөгөөг боловсруулан 2021 оны 9 дүгээр сарын 10-аас 10 дугаар сарын 29-ны хооронд 3 аудитор оролцож, 48 өдөр зарцуулан аудитыг гүйцэтгэлээ. Аудитын тайланг Тэргүүлэх аудиторын А/32 дугаар тушаалаар баталгаажуулан 2021 оны 10 сарын 29-ний 390 тоот

албан бичгээр ҮАГ-ын Аудитын Гуравдугаар Газарт болон аймгийн ИТХ, Засаг дарга, Санхүүгийн хяналт аудитын албанд хүргүүлж ажиллалаа.

Аудитаар дотоод аудитын нэгжийн чиг үүргийг хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй, үйл ажиллагааг стандартын дагуу бүрэн зохион байгуулаагүй, дотоод аудитын тогтолцоо оновчгүйгээс үр нөлөөтэй шийдвэр гараагүй зэрэг зөрчил илэрч **“Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, эрх зүйн асуудлыг шинэчлэх шаардлагатай байна”** гэсэн ерөнхий дүгнэлтийг хийж дотоод аудитын тогтолцоо чиг үүргийн хэрэгжилт үр дүнг сайжруулах 6 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, санхүүгийн бус үр өгөөжөөр бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.



“Дотоод аудитын нэгжийн бүтцийг “босоо” тогтолцоонд шилжүүлэн үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, төсөв санхүүг бие даасан, хараат бус байх нөхцөлийг бүрдүүлж, эрх зүйн орчинг олон улсын стандартад нийцүүлэх шаардлагатай байна” гэсэн саналыг ҮАГ-т уламжилж ажиллалаа.

Аудитын үр дүн: Аудитаас хүргүүлсэн зөвлөмжүүд хэрэгжсэнээр дотоод аудит хараат бусаар ажиллах нөхцөл бүрдэж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдах үр дүн бий болохоор байна.

ТӨРӨӨС ЭМИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



54 эмийн сан, 4 ЭХНБ-үйл ажиллагаа, 2,405.9 сая төгрөгийн ЭМДС-ийн санхүүжилт шалгав.



2 албан шаардлага, 7 зөвлөмж дараа онд хэрэгжихээр байна.

Нэгдсэн төлөвлөгөөт тус аудитыг 2021 оны 9 дүгээр сарын 25-аас эхлэн гүйцэтгэсэн бөгөөд аудитад 2 аудитор 42 өдөр зарцуулж Тэргүүлэх аудиторын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/33 тушаалаар баталгаажуулан 410 тоот албан бичгээр ҮАГ-ын Аудитын гуравдугаар газар, Аймгийн ИТХ, Засаг дарга, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, ЭМДХ, МХГ-дад тус тус хүргүүлсэн. Аудитын нээлтийг цахим

хэлбэрээр зохион байгуулж, ажлын баримтыг цахимжуулан архивд хүлээлгэн өглөө.

Аудитаас **“Аймгийн хэмжээнд төрөөс эмийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнээгүй байна”** гэсэн ерөнхий дүгнэлтийг хийж, 2 албан шаардлага, дотоод хяналт үйл ажиллагааг сайжруулж, эмийн сан, ЭХНБ-дад олгох тусгай зөвшөөрлийг холбогдох хуульд нийцүүлэн ажиллах 7 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, **1,108.9** сая төгрөгийн 2 санхүүгийн, 7 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

Аудитын үр дүн: Аудитын шийдвэрийн хэрэгжилт хангагдсанаар ХАА-ны тухай хууль болон дотоод хяналт сайжрах, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт хангагдах үр дүн бий болохоор байна.





4

ИТХ-ЫН ЗАХИАЛГАТ БОЛОН ӨӨРИЙН САНААЧЛАГААР ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

Гүйцэтгэсэн аудит



Өөрийн санаачлага 2
ИТХ-ын захиалгат 2



10 хүн /давхардсан
тоогоор/ 132 өдөр
зарцуулж 48 цаг илүү
ажилласан



Нийт 4,697.7 сая
төгрөгийн алдаа зөрчил
илэрсэн



1.1 сая төгрөгөнд 1
төлбөрийн акт
хүргүүлж, биелэлтийг
100 хувь хангууллаа.



1,265.0 сая төгрөгөнд
9 албан шаардлага
хүргүүлж, биелэлтийг
100 хувь хангууллаа.



3,757.9 сая төгрөгөнд
50 зөвлөмж хүргүүлж,
3,757.9 сая төгрөгийн
40 зөвлөмжийн
хэрэгжилтийг
хангуулж, 10 зөвлөмж
дараа онд биелэхээр
байна.



5,024.0 сая төгрөгийн 28 санхүүгийн, 22 санхүүгийн бус үр өгөөж
хүлээн зөвшөөрүүлж бүртгэсэн.



АЙМГИЙН ИТХ-ЫН ЗАХИАЛГААР ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

АЙМГИЙН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2019-2020 ОНЫ ЗЭЭЛИЙН ҮР ДҮН, ЭРГЭН ТӨЛӨЛТ"- Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ



30 ТАХ-нд 2 тэрбум төгрөг ЖДҮХС-аас олгосон



30.0 сая төгрөгийн 3 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлж хэрэгжилт 100%-тай байна.

Аймгийн ИТХ-ын захиалгаар хийхээр төлөвлөгдсөн тус аудитыг 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн гүйцэтгэсэн бөгөөд аудитад 2 аудитор оролцож 42 өдөр зарцуулан Тэргүүлэх аудиторын 2021 оны 10 дугаар сарын 21-ны А/31 тоот тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг дарга, ХХААГ-т хүргүүллээ.

Аудитаар **“ЖДҮХС-аас олгосон зээлийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан байна”** гэсэн ерөнхий дүгнэлтийг зарим зээлдэгчийн үйл ажиллагаанд ХХААГ-аас хяналт тавьж ажиллаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүдэд 3 албан шаардлага, үр нөлөө дээшлүүлэх 3 зөвлөмжийг өгч биелэлтийг хангууллаа.

Аудитын үр дүн: Аудитаас 30.0 сая төгрөгийн 3 санхүүгийн, 3 санхүүгийн бус үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлэн биелэлтийг 100% хангуулснаар ЖДҮХС-аас олгосон зээлийн эргэн төлөлт, зарцуулалт болон ажлын байр нэмэгдсэнд тавих хяналт сайжирсан үр нөлөөг бий болголоо.

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2020 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ



6,086.2 сая төгрөгийн 162 ТАХ-г хэрэгжүүлсэн



326.9 сая төгрөгийн 1 албан шаардлага 3592.9 сая төгрөгийн 24 зөвлөмж хүргүүлж хэрэгжилт 100%-тай байна.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн гүйцэтгэсэн бөгөөд аудитад 3 аудитор оролцож 36 өдөр зарцуулан Тэргүүлэх аудиторын 2021 оны 5 дугаар сарын 11-ний А/17 тоот тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг даргад, сумдын Засаг дарга нарт хураангуй тайлан хүргүүллээ.

Аудитын нээлтийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, ГХБХБГ, аймгийн ОНӨГ-ын холбогдох мэргэжилтнүүдийн хүрээнд хийж аудитын төлөвлөгөө хөтөлбөрийг танилцуулсан бол аймгийн бүх сумдын

Засаг дарга, ИТХ-ын дарга, Санхүү албаны дарга, нягтлан бодогч нарын 68-н албан албан тушаалтанд онлайнаар холбогдож аудитын нээлтийг хийж төлөвлөгөө, хөтөлбөрийг танилцуулж харилцан санал солилцож ажиллалаа. Аудит хийж байгаа цаг хугацаанд Ковидтой холбоотой хөл хорио тогтоосон аймгийн Засаг даргын захирамж гарч 2021 оны 4 сарын 15-аас 25-ыг дуусталх хугацаанд тэг зогсолт хийсэн тул аудитын гүйцэтгэлийн үе шатанд хийгдэх зарим ажлууд хязгаарлагдаж, баримтад тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

Аудитаар **“Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг бүрэн төлөвлөж, зарцуулахгүй байна”** гэсэн дүгнэлтийг хийж нийт **3,919.8** сая төгрөгийн зөрчил илэрч 326.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3 **,592.9** сая төгрөгийн зөрчилд 24




зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт хураангуй тайлангаар хүргүүлэн биелэлтийг 100% хангуулан ажиллалаа.

Аудитын үр дүн: Аудитаар 3919.8 сая төгрөгийн 21 санхүүгийн, 4 санхүүгийн бус үр өгөөжийг харилцагч талуудаар хүлээн зөвшөөрүүлж ОНХС-ийн хөрөнгө хууль, журмын дагуу төлөвлөгдөн, зарцуулагдаж түүнд тавих шат шатны ИТХ-ын хяналт сайжирч цаашид гарах аливаа эрсдэлийг таслан зогсоож, урьдчилан сэргийлэх үр дүнг бий болгон ажиллалаа.

➤ **ӨӨРИЙН САНААЧИЛГААР ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ**



“ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

	967.4 сая төгрөгийн 11 ТАХ-г тайлант жилд хэрэгжүүлсэн байна.
	1.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт 396.0 сая төгрөгийн 2 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлж биелэлт 100%-тай байна.

Аудитад орон нутгийн авто замын сан, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн **1,229.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-ний төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, үр дүнд чиглэн 3 байгууллагыг хамруулан 2021 оны сарын 12-ны өдрөөс эхлэн гүйцэтгэсэн бөгөөд аудитад 2 аудитор 21 өдөр зарцуулан Тэргүүлэх аудиторын 2021 оны 05 дугаар сарын



11-ны өдрийн А/15 тоот тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүллээ.

Аудитаар Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн зарим төсөл арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, зорилтод түвшинг хангаагүй нь төлөвлөлтийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй, хэрэгцээ шаардлагыг тооцоогүй, зураг төсвийг хийдэггүй зэрэг зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, үр ашгийн сайжруулах 3 зөвлөмжийг аймгийн Засаг дарга болон холбогдох албан тушаалтнуудад хүргүүллээ.

Аудитаас “Авто замын сан, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлын төлөвлөлт үр нөлөө багатай, арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна” гэсэн дүгнэлтийг өглөө.

Аудитын үр дүн: Аудитаар 397.1 сая төгрөгийн 2 санхүүгийн, 3 санхүүгийн бус үр өгөөжийг бүртгэж, харилцагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж, биелэлтийг 100% хангуулан, ТЭЗҮ зураг төсөв бүхий ажлыг ИТХ-аар батлуулдаг болж, дотоод хяналтыг сайжруулсан үр өгөөж бий болгон ажиллалаа.

“ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ

	Түгээмэл тархацтай ашигтмалтын тусгай зөвшөөрөл аймагт олгогдоогүй ч 115.7 сая төгрөгийн орлог төсөвт төвлөрүүлсэн
	10 заалт зөвлөмжийн хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.

Аудитыг 2021 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн гүйцэтгэсэн бөгөөд аудитад 3 аудитор оролцож 33 өдөр зарцуулан Тэргүүлэх аудиторын 2021 оны 10 дугаар сарын 13-ний А/29 тоот тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг даргад, сумдын Засаг дарга нарт хураангуй тайлан хүргүүллээ. Аудитаар аймгийн ИТХ болон Засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй, төлбөрийн орлогыг тооцоо судалгаанд

үндэслэн төлөвлөөгүй, түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн





хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжгүй тул хууль бус олборлолт хийгдэг зэрэг зөрчилтэй асуудлууд илэрч **“Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна”** гэсэн дүгнэлтийг хийж 10 заалт бүхий зөвлөмжийг аймгийн ИТХ, Засаг дарга, МХГ, БОАЖГ-дад тус тус хүргүүлээ.

Илэрсэн зөрчил, илрүүлэлтийн талаар орон нутгийн удирдлагууд, мэргэжлийн байгууллагуудтай уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулж хэлэлцүүлгээс гарсан санал болон хуулийн хэрэгжилтийн байдалд нэгдсэн удирдамжаар аудит хийх саналыг ҮАГ-ын Нэгдүгээр газарт 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 360 тоот албан бичгээр уламжилж ажиллалаа.

Аудитын үр дүн: Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль нь манай аймгийн хэмжээнд хэрэгжих боломжгүй, 2014 онд хууль батлагдсанаас хойш хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хяналт сул байсныг тус аудитаараа алдаа зөрчил, хүндрэл бэрхшээлтэй нь хөндөн гаргасан нь цаг үеэ олсон, гарц шийдэл гаргасан үр дүнтэй аудит болсон.

Шийдвэрийн биелэлтийн хугацаа 2022 оны 3 дугаар улиралд хангагдахаар байгаа бөгөөд шийдвэрийн хэрэгжилтийг хангуулснаар байгалийн баялаг үнэгүйдэх, байгаль орчин эвдэрч сүйдэх, нөхөн сэргээгдэхгүй байх эрсдэлээс урьдчилан сэргийлэгдэх төдийгүй хуулийн хэрэгжилт бүрэн хангагдах үр дүн бий болохоор байна.





5 | ДОТООД АЖИЛ

Төрийн Аудит





Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 онд хэрэгжүүлэх дотоод ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.

ОНЦЛОХ АЖЛУУД

1. Тамгын даргаар ахлуулсан ажлын хэсэг орон нутагт ажиллах явцад аймгийн Засаг даргад ажилтнуудын *нийгмийн асуудлыг* шийдвэрлэх санал тавьсны дүнд 5 албан хаагчид *гэр бүлийн хэрэгцээний газар* олгон, орон нутгийн хөрөнгөөр ажлын 5 өрөөнд 8.0 сая төгрөгийн засвар хийж, 2.0 сая төгрөгийн тавилга худалдан авч ажилтнуудын ажиллах орчин нөхцөлийг сайжрууллаа.
2. ҮАГ-аас олгосон санхүүжилтийн дагуу 20.0 сая төгрөгөөр зөөврийн болон суурин компьютер, хэвлэгч зэрэг техник хэрэгслийг худалдан авч тоног төхөөрөмжийг шинэчлэлээ.
3. Албан хаагчдын нийгмийг асуудлыг шийдвэрлэхэд 2 ахлах аудитор тус бүрд 5.0 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олголоо.
4. “Сайн үйлсийн аян”-ны хүрээнд Цэцэрлэг хотын тохижилт үйлчилгээний газрын таван ажилтанд халуун аарцаар үйлчилж, ажилтнууд хуримтлалаасаа тус бүр 50.0 мянган төгрөгийн үнэ бүхий зүйлийн дэмжлэг үзүүллээ.
5. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр *нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт* хамрууллаа.
6. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэж аймгийн төв дэх “Булган уул”-ын энгэрт мод тарилаа.
7. Авилгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний дагуу “*Авлигын эсрэг бид хамтдаа*” эссэ бичлэгийн уралдаан зохион байгууллаа.
8. Архивын тухай хууль, холбогдох стандартын дагуу байгууллагын архивын өрөөг тохижууллаа.
9. Төрийн хяналтын 100 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд ажлын хэсгийг томилж 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлалаа.

БУСАД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЛААР

- ❖ Байгууллагын бүх ажилтнуудаар ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргуулан цахим системд оруулан баталгаажууллаа.
- ❖ ТАГ-ын ажилтнууд ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх, гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх үүднээс аудит бүрийн эхэнд аудиторууд ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл, нөлөөллийн мэдүүлгийг гарган баталгаажуулж ажиллалаа.
- ❖ Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулан, сан үүсгэн, бүртгэлээр хяналт тавьж хэвшлээ.
- ❖ Төсвийн байгууллага ТБОНӨААН-дийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, санхүүгийн тайлангийн аудитад байнга ашиглагдах ажлын баримтуудаар *цахим мэдээллийн бааз* үүсгэлээ. Аудиторуудын шаардлагатай үед хэрэгтэй мэдээллийг шуурхай авч ашиглах цаг хугацаа хэмнэсэн үр дүнтэй ажил боллоо.
- ❖ “Хөрөнгө оруулалтын цахим мэдээллийн сан”-г Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2020 төлөвлөгөөний дагуу орон нутагт хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллээр баяжууллаа.





- ❖ Чанарын баталгаажуулалтын газрын зөвлөмжийн дагуу аудитад хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэн, биелэлтийг үнэлэн хүргүүллээ.
- ❖ “Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах сарын аян”-ыг зохион байгуулж төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулсан ач холбогдолтой арга хэмжээ боллоо.
- ❖ Байгууллагын эмэгтэй ажилтнууд болон ажилтнуудын хүүхдүүдэд дотоод журмын дагуу 1.3 сая төгрөгийн гарын бэлэг өглөө.
- ❖ Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ажиллагсдадаа амны хаалт маск, дархлааг дэмжих чацаргана, витамин, гар ариутгагч зэрэгт 1.3 сая төгрөг зарцууллаа.
- ❖ 2021 онд Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр тэтгэвэр тогтоолгох насанд хүрч төрийн албанаас чөлөөлөгдсөнөөр аудитын менежер Т. Байгалмаа Тэргүүлэх аудитораар томилогдлоо.
- ❖ Ахлах аудитор Д.Нэргүйбаатар, аудитор Х.Алтанчимэг, нягтлан бодогчийн ажлыг гэрээгээр гүйцэтгэж байсан Л. Соёлмөнх нар МУЕА-ын дэргэдэх тусгай шалгалтад тэнцэж төрийн албаны тухай хуулийн дагуу шатлан дэвших зарчмын дагуу шинээр томилогдлоо.
- ❖ Аудитор Л.Соёлмөнх ЗУГ-с зохион байгуулсан “Төрийн аудитын байгууллагын ажилтны тангараг” өргөх ёслолд оролцож, цахимаар тангараг өргөлөө.

МЭРГЭЖЛИЙН ТАСРАЛТГҮЙ СУРГАЛТ

Ажилтнууд ХБТГ болон ҮАГ-ын төрөлжсөн газруудаас зохион байгуулсан сургалтад бүрэн хамрагдлаа.

- ❖ “Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын сургалт хөгжлийн нэгдсэн систем”-д байршуулсан “Төрийн аудитын суурь ойлголт, стандартын хэрэглээ”, “Эдийн засгийн бодлогын шинжилгээ” цахим сургалтад албан хаагчид бүрэн хамрагдлаа.
- ❖ ТАГ-ын ажилтнуудыг ажлын байранд тасралтгүй сургах, хэрэгцээ шаардлагад тулгуурлан чадавхжуулах үүднээс аудиторуудаас санал асуулга авч, үнэлэн тэдний хэрэгцээ, шаардлагад тулгуурлан Мэргэжлийн тасралтгүй сургалтын төлөвлөгөөг Тэргүүлэх аудиторовын 2021 оны А/14 тушаалаар батлан хэрэгжүүллээ. Мэргэжлийн тасралтгүй сургалтын хүрээнд өөрсдийн аудиторуд болон Насан туршийн боловсролын төв, Татварын хэлтэс, Төрийн албаны зөвлөлийн сургагч багшаар хичээл заалган сургалтад давхардсан тоогоор 187 хүн хамрагдсан байна.





➤ АЛБАН ХАРИЛЦАА, МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА

Албан хэрэг хөтлөлт архивын үйл ажиллагаа

Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт нь байгууллагын дотоод үйл ажиллагаандаа ЭБЛ (ABLE) системийг тогтмол ашиглан, долоо хоног бүрийн **Даваа** гаригт **Мэдээллийн цаг** хийж хэвшсэн. Мэдээллийн цагаар өмнөх долоо хоногт хийсэн ажлын гүйцэтгэл, үүрэг даалгаврын хэрэгжилтийг танилцуулж, харилцан ярилцаж, шинэ долоо хоногийн үүрэг даалгаврыг өгч ажиллаж ирлээ.

2021 онд Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирсэн албан бичиг 804 ҮАГ-аас 57 бусад байгууллагаас 747 ирснээс хариутай бичиг 51 ирснийг шийдвэрлэсэн байна. Мөн 456 албан бичиг гарснаас 40 нь ҮАГ-т, бусад нь гадны албан байгууллагуудад хүргэгдсэн, 141 хариутай бичгийн хариу бүрэн ирсэн. Ирсэн, явсан бичиг, акт, албан шаардлага, зөвлөмж, гэрчилгээнүүдийг тухай бүр цахим файлын санг үүсгэн архивлаж, баримт бичгүүдийг цахим санд оруулан ажиллалаа. Тайлант онд иргэд төрийн байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт 14 ирснээс ажилтнуудын чөлөө хүссэн дотоод үйл ажиллагаатай холбоотой 4, аудит хийлгэх 1, бусад 9 өргөдөл ирснийг цаг тухайд нь шийдвэрлэсэн байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой нийт 69 тушаал гарсан байна.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 онд байгууллагын архивд 170 хавтас аудитын ажлын баримтыг хадгаламжийн нэгж болгон архивлалаа.

Мэдээлэл түгээх, харилцагч талуудын оролцооны талаар

Байгууллагын үйл ажиллагааны талаарх товч тайлан болон аудитын явцын мэдээллийг 14 хоног тутам Захиргаа удирдлагын газар, www.data.audit.mn цахим системд байршуулан ажиллаж ирлээ. 2021 оны 10 дугаар сарын 28-нд АНТАГ-дын удирдлагын шуурхай хуралдаанд байгууллагын эхний 10 сарын ажлын гүйцэтгэлийг цахимаар танилцуулж ажиллалаа.


МУЕА-ын 2019 оны А/10 тушаалаар баталсан **“Төрийн аудитын 2019-2023 онд хэрэгжүүлэх харилцагч талуудын оролцооны стратеги төлөвлөгөө”**-ний дагуу харилцагч талуудын оролцооны 2021 оны төлөвлөгөө, Тэргүүлэх аудиторын 2021 оны өдрийн А/18 дугаар тушаалаар “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулж тайланг харилцаа хамтын ажиллагааны газарт цахимаар хүргүүлээ.

МЭДЭЭЛЛИЙН ЦАГ
Өдөр: 2021.10.11-2021.10.18

Яригдсан асуудал:

- Өмнөх долоо хоногт хийгдсэн ажилуудын талаар ярилцлаа. Үүнд:
- ТТAMIX ний хэрэгжилт аудитын илэрүүлэлтээр Айвгийн ИТХ чин дарга болон холбогдох хэргээсийн байгууллагуудын төлөөлөгчид оролцоулан хэлэлцүүлэх зохион байгуулнаас.
- Түрээсийн аудитын явцын талаарх мэдээлэл солилцоо.

№	Харилцагч талуудын нэр	Харилцаа өдөр	Хариуцах хугацаа	Түрэг доторх ажиллагаа
1	Архангай аймаг дахь төрийн аудитын газар	2021.10.14		
1	Гүйцэтгэлийн төлөөлөгчийн даргуудын 2022 оны төсвийн төсвийн орлого нэмэгдүүлэх төслийн төлөвлөгөөний дүн шалгалтын үйлсийн талаар судалгаа, төсвийн үнэмлэхүй рингэлдэв, хэлэлцүүлэх багц	Н. Алтануяа Ж. Мөнхшарай П. Энхбаатар	2021.10.14	
2	ЖДҮС-ийн 2019-2020 оны эхний үр дүн, эргэн харах үндэслэл, аудит, Түрээст тасарчтай ашигт мэдээллийн тухай ажиллагааны гүйцэтгэлийн тайланг үнэмлэхүй хяналт хийсэн, тайланг УХЗ-р хэлэлцүүлэн, үнэмлэхүйгээр хүргүүлэх	Алтан Б. Азгуу Аудитор П. Энхбаатар П. Цэрэгдулам	2021.10.15	
3	Нэгдсэн төлөвлөгөөт аудит Төрийн хувийн аюулгүй байдлыг хангах өмчийн хөтөлгөө, төсвийн захиураас хөрөнгийн үр дүн, Төрийн байгууллагын дотоод аудитын тогтолцоо, шиг үүргийн хэрэгжилт өргөдөл үр шалтгааныг хяналт	Алтан Б. Азгуу Д. Хэрэгдулам С. Цог П. Цэрэгдулам	2021.10.15	
4	Төрийн эдийн талар барилгатай болон хэрэгжилтийн судалгаа үр дүн, шалгалтын аудитын ажлыг АНЗС-ийн аудитын ажлыг баримтат ажилтнуудын өгөг мэдээлэл судалгаа хяналт үр ажиллагаа	Х. Алтаншарай	2021.10.15	






2021 онд аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга, шалгагдагч байгууллагуудад 183 тайланг хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ, ЗДТГ-аас зохион байгуулсан “Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарын зөвлөгөөн”-д Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа оролцож “Төрийн аудитын байгууллагын шийдвэрийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” сэдэвт илтгэл тавилаа.

Аймгийн “Тамир” телевизийн “Толь” мэдээллийн хөтөлбөрт Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа ярилцлага өгч байгууллагын 2021 оны үйл ажиллагааны үр дүнг олон нийтэд мэдээллээ.


Төрийн аудитын байгууллагын нэгдсэн мэдээллийн www.audit.mn цахим сайтад Санхүүгийн тайлангийн аудитын 173, гүйцэтгэлийн аудитын 2, нийцлийн аудитын 2 тайлан, цаг үеийн шинжтэй 30 мэдээллийг сайтаар мэдээлж ажиллалаа. “Архангай Аудитын газар” Facebook хуудсаар байгууллагын үйл ажиллагааны тайлан, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх видео танилцуулга, гэрээт ажилтан шалгаруулах зэрэг 25 мэдээллийг олон нийтэд түгээж ажилласан бөгөөд facebook хуудасны хандалтын тоо 1980 хүрсэн байна.



БАЙГУУЛЛАГЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ

1 Төсвийн гүйцэтгэл

Батлагдсан төсвийн дагуу урсгал зардалд 559.2 сая төгрөгийн санхүүжилт авч, 514.1 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд 91.9 хувийн гүйцэтгэлтэй байна.



2021 оны төсвийн нийт зарцуулалт 91.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр нийт төсвийн 383.8 сая төгрөг буюу 74.6 хувийг цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллын зардалд, 48.5 сая төгрөг буюу 9.5 хувийг НДШ-ийн зардалд, 2.2 сая төгрөг буюу 0.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт, 10.4 сая төгрөг буюу 2.0 хувийг хангамж бараа материалын зардалд, 20.0 сая төгрөг буюу 3.9 хувийг багаж техник хэрэгслийн зардалд, 9.0 сая төгрөг буюу 1.8 хувийг томилолт болон хичээл үйлдвэрлэлийн зардалд, 40.2 сая төгрөг буюу 7.8 хувийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд зарцуулаад байна.

Байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, анхан шатны баримт холбогдох бусад санхүүгийн баримт бичгийн хамт төсвийн цаглабарт хугацаанд “Мишээл Од Аудит” ХХК-д шалгуулан ЗӨРЧИЛГҮЙ санал дүгнэлт авлаа.

2 Төсвийн төсөл

Төрийн аудитын газрын 2022 оны төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 27 дугаар зүйлд заасны дагуу боловсруулан төсвийн цаглабарыг баримтлан бэлтгэж 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 235 тоот албан бичгээр төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээ.



3 Шилэн дансны мэдээллийг бүрэн байршууллаа



Байгууллагын 2021 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим сайтад байршуулвал зохих нийт 151 мэдээллийг 100 хувь бүрэн хугацаанд нь байршууллаа. Цахим системийн хөтлөлтийн 4-р улирлын тайланг хугацаанд нь илгээгээд байна.

Мөн хуулийн 6.4.4, 6.4.5-д заасны дагуу нийт 559.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлого, 145.3 сая төгрөгийн зарлагын нийт 31 удаагийн гүйлгээ, 96.9 сая төгрөгийн 17 тушаал шийдвэр байршууллаа. Хуулийн дагуу аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаанд нь мэдээлсэн.

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТЭЭР 32.7 САЯ ТӨГРӨГИЙН ОРЛОГЫГ ТӨВЛӨРҮҮЛЛЭЭ

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 2021 онд аудитын үйлчилгээний хөлсөөр 32.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийн санхүүжилт нийт 42.7 сая төгрөгийн орлого төвлөрснөөс ажил гүйцэтгэх гэрээний дагуу аудитын хуулийн этгээдэд 10.8 сая төгрөгийг шилжүүлж, Сангийн сайдын 217 дугаар тушаал, МУЕА-ын А/114 дүгээр тушаалаар 16.7 сая төгрөгийн нэмэлт орлогыг зарцуулах эрхийг олгосноор ажилчдын нийгмийн асуудал 10.0 сая төгрөгийг, тавилга эд хогшил худалдан авахад 6.7 сая төгрөгийг, мөн аймгийн Засаг даргын захирамжаар олгосон 10.0 сая төгрөгийг конторын урсгал засварт зориулалтын дагуу зарцуулж Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудал, ажиллах орчинг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга эд хогшилоор бүрэн хангаж ажиллалаа.



7 | ДҮГНЭЛТ, САНАЛ

Төрийн аудитын байгууллагаас 2021 оныг “Аудитыг цахимжуулж, нэгтгэн удирдах тогтолцоог төлөвшүүлэх” зорилт дэвшүүлсний дагуу Архангай аймаг дахь Төрийн аудитын газар төрийн аудитын байгууллагын нэгдмэл удирдлагын дор хуулиар хүлээсэн чиг, үүрэг үйл ажиллагаагаа орон нутгийн түвшинд төлөвлөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 5 бүлэг, 9 зорилтын 41 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллалаа.

Төрийн албаны хуулийн хэрэгжилтийн хүрээнд төрийн албаны сул орон тоонд байгууллагын хүн хүчний дотоод нөөц боломжид тулгуурлан шатлан дэвших зарчмаар албан тушаалтнуудыг томилсон нь байгууллагын үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг болсон үйл явдал боллоо.

Төрийн аудитын газар нь 2021 онд батлагдсан сэдвийн хүрээнд 163 аудитыг чанар, стандартын шаардлагад нийцүүлэн төлөвлөгдсөн хугацаанд гүйцэтгэснээс орон нутгийн төсөвт 99.7 сая төгрөгийг төвлөрүүлж, **54081.7** сая төгрөгийг аудитад хамрагдсан байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсэн нь төсвөөс авсан нэг төгрөгийн санхүүжилт тутамд **105.2** төгрөгийн үр өгөөжийг бий болгосон байна.

Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Төрийн аудитын газраас 2022 оны орон нутгийн төсвийн орлого нэмэгдүүлэх 781.2 сая төгрөг, үр ашиг дээшлүүлэх 7-н санал бүхий аудитын дүгнэлтийг аймгийн ИТХ, Засаг дарга нар хүлээн авч төсвийн төсөлд бүрэн тусгажээ.

Төрийн аудитын газар нь 2021 онд төсвөөс 514.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажилтнуудын нийгмийн хамгаалал, ажиллах нөхцөлийг сайжруулсан, техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан жил боллоо.

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Төрийн аудитын газар